



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 01

Бүрхээр

Могойн гол ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хорин зургаа дугаар хурал Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Нутгийн удирдлагын ордон А-байр, 3-р давхар Иргэний танхимд 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 11 цаг 30 минутад болов.

Хуралд нийт 829622 /Найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин хоёр/ширхэг хувьцаа эзэмшигч оролцохоос / 733,015 / ширхэг хувьцаа эзэмшигч, Орон нутгийн төлөөлөгч 1, бусад хувьцаа эзэмшигчид 5 ширхэг биеэр, итгэмжлэлтэй оролцогч 5 ширхэг оролцож хурлын ирц 88,3% хувьтай болж Монгол улсын компанийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.1, Могойн гол ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дэхь заалтыг хангасан учир тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай танилцуулав.

Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн ээлжит 26 дугаар хурлаар хэлэлцэхээр Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон хурлын дэгийг танилцуулж, хурлыг нээж асуух асуулт гаргахыг мэдэгдэв. /Тооллогын комиссын тогтоол хавсаргав/

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 26 дугаар хуралд: Хувьцаа эзэмшигч

| № | Овог нэр                    | Төлөөлөл                                                    | Регистерийн<br>дугаар | Хувьцааны<br>тоо |
|---|-----------------------------|-------------------------------------------------------------|-----------------------|------------------|
| 1 | Цэрэнжав<br>овогтой Бэхбаяр | Орон нутгийн<br>өмчийн 51%-ийг<br>итгэмжиллээр<br>төлөөлөгч |                       | 423107           |
| 2 | Ж.Батболд                   |                                                             | TE64010314            | 135451           |

|   |               |                 |              |        |
|---|---------------|-----------------|--------------|--------|
|   |               | Транс нефть ХХК | 204660399777 | 124444 |
|   |               | Гомбо Мөнхцэцэг | ХЛ67092100   | 6000   |
|   |               | Далхжав Амгалан | ДВ69060815   | 100    |
|   |               | Булган Брокер   | 2008157      | 4180   |
|   |               | Булган Брокер   | 2008157      | 100    |
| 3 | Л.Батдэлгэр   |                 | ЙТ54081510   | 23067  |
| 4 | Ч.Гүнсэnnоров |                 | ЙТ60021503   | 15098  |
| 5 | Т.Бат-Очир    |                 | РС62112614   | 1311   |
| 6 | Ц.Мөнгөншагай |                 | ФА79120233   | 157    |

Тооллогын комиссын дарга: Г.Өнөржаргал

Тооллогын комиссын гишүүн : Б.Золбоо

Тооллогын комиссын гишүүн Б.Батзаяа нар оролцов.

**ХЭЛЭЛЦСЭН нь 1: Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт**

**СОНССОН нь:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Базардамбуу танилцуулав.  
/танилцуулгыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигч Ж.Батболд: Өнөөдөр манай компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болж байна. Энэ хуралд хүрэлцэн ирсэн та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ удаагийн хурал бол маш их ач холбогдолтой, нэн чухал асуудлуудыг хэлэлцэж байгаа. Өнгөрсөн он жилүүдэд компани маань ахиц дэвшилтэй ажиллаж ирсэн. 2017, 2018, 2019 онуудад манай компани ахиц дэвшилтэй ажиллаж байсан. 2019 оны хагасаас манай компанийн үйл ажиллагаа доголдож эхэлсэн. Өмнөх онд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гишүүд сайн ажиллаж өнөөдрийн үр дүнд хүрсэн. Компанийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг дэмжиж байна. Энэ асуудалтай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын үр дүн хангалттай байна гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч Л.Батдэлгэр: 2019 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж ирснийг тэмдэглэе. Цаашид Төлөөлөн удирдах

зөвлөлийн хурлыг тогтмолжуулах хэрэгтэй. Шинээр байгуулагдах ТУЗ үүнийг маш сайн анхаарч ажиллаарай. Зарим үед ТУЗ-ийн хурлыг 2, 3 сараар хойшлуулах асуудал гарч байсан. Цаг хугацаандаа хуралдаж компанийнхаа асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Компани ч ялгаагүй асуудлуудаа хугацаа алдалгүй ТУЗ-д танилцуулж байх хэрэгтэй. Компанийн хувьд нөхцөл боломжоо сайтар ашиглаж чадахгүй байна уу даа гэж харж байна. Манай компанийн хамгийн гол зүйл нь нүүрсний борлуулалт.

Манай компани бол ашгийн байгууллага. Цаашид ашиг орлогоо нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмжөө шинэчлэх шаардлагатай. Нүүрс борлуулаад гаргахад хэрэгцээтэй бол шууд л нийлүүлдэг байх хэрэгтэй. Цаашид бүх боломж нөхцөлийг бүрдүүлж ажиллахад онцгой анхаарах хэрэгтэй. Жишээлбэл 12 сард 5 мян.тонн нүүрс авъя гэсэн газарт нь нийлүүлчихсэн бол одоо асуудал байхгүй. Тайлангийн тухайд дэмжиж байна.

Орон нутгийн өмчийн төлөөлөгч Ц.Бэхбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. "Могойн гол" ХК-ийн 51% буюу 423107 ширхэг хувьцаа нь орон нутгийн өмч байдаг. Үүнийг төлөөлж энэ хуралд оролцож байгаадаа баяртай байна. Аймгийн ИТХ-с хэлэлцэх асуудалтай холбоотой удирдамж чиглэл өгсөн. Үүний дагуу би энэ хуралд оролцож байна. Өнгөрсөн жил Могойн гол ХК-ийн хувьд санхүүгийн тал дээр өсөж байгаад зогсолт хийсэн жил байлаа. Бид бүхний хувьд тал талын боломж нөхцөлийг харж, эрсдэлүүдийг тооцож, гарах арга замуудыг эрэлхийлж ажиллах том сорилт, сургамж болсон он жил болж өнгөрлөө гэж үзэж байна. Компанийн тухайд бүхий л боломжоо дайчлан ажиллаж түүхэндээ анх удаа 1 сая м.куб хөрс хуулсан компанийн нийт ажилчиддаа талархал илэрхийлэх нь зүйтэй. Компанийн ТУЗ 2019 онд тодорхой арга хэмжээнүүдийг авч ажилласан. Гэхдээ цаашид бид урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөтэй, том зорилттой, тал талын эрсдүүлийг тооцож ажиллах шаардлага үүсэж байна.

Ц.Мөнгөншагай: Санал байхгүй.

Хувьцаа эзэмшигч Н.Гүнсэnnоров: Би "Могойн гол" хувьцаат компанийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөл байдлын талаар мэдэж байна. Ажилчдын хувьд 1 сая м.куб хөрс хуулна гэдэг нь бахархууштай зүйл. Гэхдээ ажилчдын дунд ойлгомжгүй шүүмж байгааг олж мэдсэн юм. Энэ нь ТУЗ дан ялангуяа хувьцаа эзэмшигчид энэ компаниар тоглож байна. Ашиггүй ажиллаж байна гэх зэрэг зүйлс яригдаж байна. Та бүхэн бидэнд мэдээлэл дутуу өгдөг юм байна. ТУЗ-ийн хурлыг компани дээр нь очоод хийж болно. Илүү өргөтгөсөн байдлаар компанийн ажилчдыг байлцуулан хийж болно шүү дээ. Бид их, бага гэлтгүй хувьцаа эзэмшиж байгаа нь компани ашигтай ажиллаж хэдэн төгрөгний ногдол ашиг тараахыг харж байгаа. Гэтэл өнөөдөр төрийн төлөөлөл энэ компанийн үйл ажиллагаанд хэтэрхий оролцоод байгаа нь харагдаж байна. Экспортын зориулалтын нүүрс тээвэрлэлтийг нь хориглочихсон. Тэгсэн хэдий ч дулааны станцын нүүрсийг авахын тулд компанийн удирдлагуудад шахалт өгөөд зээлээр нүүрс авахуулчихдаг. Өнөөдөр уурхай удирдлагуудаа, ТУЗ-ийн гишүүд та нарыг буруутгаж байна шүү дээ. Энэ асуудал дээр та бүхэн бодитой мэдээлэл өгөөсэй, ажилчдад энэ мэдээллийг хүргээсэй гэж бодож байна. Та бүхэн яагаад экспортын нүүрсийг тээвэрлүүлж болоогүй юм бэ. Компанийн үйл ажиллагааны талаар асуумаар байна. Өнгөрсөн жил уурхайд осол гарсан та бүхэн бүгд мэдэж байгаа байх. Тухайн жолооч ажилд ороод 1 сарын дараа

осол гаргасан байна. ажилчдын туршилтын хугацаа 3 сар байдаг биз дээ. Гэтэл тухайн жолооч осол хийгээд гарсан хохирол, төлбөр мөнгийг хэн төлөх үү? Үүн дээр ямар арга хэмжээ авсан юм. 50,60 гаран сая төгрөгөөр онгоц авчирсан байсан. Энэ чинь бидний мөнгөөр хийгдэж байгаа шүү дээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Базардамбуу: Өнөөдрийн хуралд компанийн гүйцэтгэх удирдлага Б. Хашбат оролцож байгаа зарим асуултууд дээр хариулт өгнө.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 04 дүгээр сарын 05-ны 02 тогтоолоор экспортын зориулалттай нүүрсний тээвэрлэлтийг зогсоосон. Мэргэжлийн хяналтын газраас замын асуудал дээр анхаарах, тээвэрлэлтийн горимыг барьж ажиллах тухай удаа дараа шаардлага тавьж бичиг ирүүлж байсан. Үүнээс болж манай компанийн үйл ажиллагаа доголдож ашигт байдал муудсан. ТУЗ болон компанийн зүгээс шат шатанд нь арга хэмжээ авч өгөөч гэсэн санал хүсэлтийг удаа дараа тавьсан. Гэсэн хэдий ч энэ асуудал шийдвэрлэгдээгүй байна. Манай компани дээр улс төрийн асуудал ихээхэн орсон. Үүнээс улбаалан компанийн эрх ашиг хөндөгдсөн. Манай аймагт бусад аймгуудын нүүрс наашаа орж ирэх үед аймгийн мэргэжлийн хяналтын газраас шалгалт хийсэн зүйл байхгүй байна. Цаашид аймаг орон нутгийн удирдлагуудад санал хүсэлтийг дахин уламжилна. экспортын зориулалттай нүүрсний тээвэрлэлтийг зогсоосон нь компанийн гадаад орчны аюул занал болсон юм.

Компанийн гүйцэтгэх захирал Б.Хашбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. 2019 онд манай компанид буюу хөрсний мөргөцөг дээр машин унасан аваар гарсан. Манай компанийн тухайд туршилтын хугацаа 3 сар байдаг. Гэвч энэ удаад ХАБЭА-н зааварчилгааг дутуу өгсөн, Инженер техникийн албанаас тухайн үед жолооч маш их дутагдалтай ажил ихтэй үе байсан тул тухайн жолоочийн туршилтын хугацаа дуусаагүй үед ажилд гаргасан зэрэг алдаа дутагдал байсан. Энэ асуудалтай холбоотой 40 гаран сая төгрөг зарцуулагдсан. Цаашид ХАБЭА-г хангаж ажиллах тодорхой журам дүрэм боловсруулаад ажиллаж байгаа. Мөн ХАБЭА-н сургалт авч ажилласан өдөр тутмын ХАБЭА-н сургалт зааварчилгааг тогтмолжуулж ажиллаж байгаа. Одоогоор ХАБЭА-н ажилтнаар 2 хүн ажиллаж байгаа. Цаашид ийм асуудал дахин гаргахгүй байхыг ихээхэн анхаарч ажиллах болно оо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Базардамбуу: Төлөөлөн удирдах зөвлөл 2019 оны 6 сард компанийн байранд очиж ажиллан ерөнхий байдал, үйл ажиллагаатай танилцаж компанийн ажилчидтай уулзалт хийсэн. Мөн Аудитийн хорооноос очиж ажиллаж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. ТУЗ-ийн шийдвэрээр компанийн нийт ажилчдыг ХАБЭА-н сургалтад хамруулсан үүнээс хойш ямар нэгэн уурхайн, ажлын байран дээрх осол аваар гараагүй.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Тогтоолын төслийг танилцуулав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

## **ХЭЛЭЛЦСЭН нь 2: Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан**

**СОНССОН нь:** ТУЗ-ийн дарга Б.Базардамбуу танилцуулав. /танилцуулгыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигч Ж.Батболд: Гарын авлага хэлбэрээр бидэнд ирсэн учир нэмэлт санал байхгүй.

Хувьцаа эзэмшигч Л.Батдэлгэр: Гарын авлага дээрээс урьдчилан танилцсан учир нэмэлт санал байхгүй.

Хувьцаа эзэмшигч Ч.Гүнсэnnоров: Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлууд дээр асуулт санал байна. Мэдээж хандив тусламж байхаас аргагүй гэхдээ яг хажууд байгаа цэцэрлэг суманд шаардлагатай зарим зүйлд зарцуулбал ард иргэд, энэ уурхайн нэр хүндэд ч хэрэгтэй. Ажилчдын ахуй хангамж ямар байгаа билээ түүнийг бодолцож өөр газруудад зарцуулж байгаа мөнгөө зөв газраа, орон нутагт нь, уурхайдаа мөн уурхайн ажилчдад зарцуулах хэрэгтэй. Ажилчдын нийгмийн асуудлыг бодож үзэх хэрэгтэй. Төр хэтэрхий орж байна шүү дээ. Гадагшаа хэтэрхий их мөнгө зарцуулдаг юм байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Базардамбуу: Урандөш зуслангийн хүрээнд ТУЗ бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдаж Хөвсгөл аймгийн нийт хэрэгцээнд, хүүхэд багачуудад нэн шаардлагатай ажил байна гэж үзсэн мөн аймгийн Засаг даргын албан тоотыг үндэслэн энэ ажлыг хэрэгжүүлсэн байна. Бүх асуудал дээр ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар батлагдаж хэрэгжиж байгаа. Эдгээр ажлууд нь нэг, хоёр хүний хэрэгцээнд шаардлагатай бус Хөвсгөл аймгийн нийт 132.0 мянган иргэдийн эрх ашгийг хүндэтгэсэн шийдвэр гэдгийг ойлгоосой гэж хүсэж байна.

Орон нутгийн өмчийн төлөөлөгч Ц.Бэхбаяр: Энэ асуудал дээр санал байна. Бид орон нутаг, цэцэрлэг сум, иргэд, ажилчдаас ирж буй саналыг тухай бүрт нь авч хэлэлцээд боломжтой шийдэл, гарц гаргалгааг гаргаж ажилладаг. Аль аль талд нь хэрэгтэй хандив тусламжийг чадах хэмжээгээрээ үзүүлдэг. Энэ дээр бидний шийдвэрүүдийг цааш нь хүргэх мэдээлэл нь дутуу байгаад байна уу гэж харж байна. Жишээлбэл бид цэцэрлэг сумын иргэдэд иргэний үнэмлэхээ авч ирээд уурхайн олборлосон зардлаар нь 2 хүртэлх тонн нүүрс авч болох шийдвэр гаргаад одоо 2 жил болж байна. Цэцэрлэг сумын иргэдээс ингэж авч чадаж байна уу гэж асуухаар ихэнх хүмүүс нь мэдэхгүй байх жишээтэй. Өмнө жил гэхэд сургууль цэцэрлэгийн халаалтыг нийтийн халаалтын шугамд энэ компанийн хөрөнгөөр холбож өгсөн. Гадна тоглоомын талбайг шинээр хийж өгсөн. Могойн голын тосгон нь гэрэл гэгээгүй харанхуй байсныг гэрэлтүүлэгтэй болгосон. Өндөр хурдны интернет сүлжээг нь холбосон. Худгийн тухайд хөрөнгийг нь баталсан боловч цэвдэгтэй газар учир техникийн нөхцөл нь болж өгөхгүй байгаа. Бид бүхэн ажлуудыг уг нь хийгээд байгаа хэдий ч мэдээлэл нь муу байгаад байна. Цаашид мэдээллийг илүү хүртээмжтэй болгох тал дээр анхаарч ажиллах болно.

Компанийн гүйцэтгэх захирал Б.Хашбат: Компанийн нийгмийн асуудал ялангуяа орон нутагт хийгдэж байгаа асуудлыг бид сумын засаг даргатай гэрээ хийж хийсэн байгаа. Эдгээр ажлуудын гүйцэтгэл нь 100%-ийн биелэлттэй гэж дүгнэгдсэн. Энэ ажлыг сумын захиргаа хариуцаж хийх ёстой үүнийг бүгд мэдэж байгаа. 2 тонн

нүүрс олборлосон үнээр нь авах тал дээр зарим тохиолдолд нүүрс нь эзэндээ хүрэхгүй байх асуудал байгаа. Тухайлбал цэцэрлэг суманд бүртгэлтэй 10-аад айлыг бөөгнүүлж байгаад нэр дээр нь нүүрс авч цааш нь дамлан зарах тохиолдол хэд хэд байсан. Тийм учраас сумаас энэ ажлыг зохион байгуулж нүүрс түлдэг айлуудыг судалгааг гарган тэдгээр хүмүүс нь уурхай дээрээс нүүрс авах гэсэн хэлбэрээр явуулъя гэсэн гэрээ байгуулсан. Сумаас энэ ажлыг зохион байгуулаагүй. Хүмүүсээ судалгаанд хамруулаагүй. 2020 онд цэцэрлэг суманд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажлууд гэрээгээр хийгдсэн байгаа. Үүнд өлийн даваа, таралжийн гүүрийг засварлах, хүүхэд итгэлийн харц аяны хүрээнд 1 сая төгрөг зарцуулсан. Мөн суманд нүүрсний цэг байгуулах ажил хийхээр төлөвлөж байгаа.

Хувьцаа эзэмшигч Т.Бат-Очир: Манай тосгоны хувьд ундны усны асуудал маш их байгаа шүү дээ. Голоос ус авч ундандаа хэрэглэх боломжгүй. Тосгоноо түшиглэж амьдарч байгаа айл өрхүүдэд цэвэр усны хангамжийг сайжруулах асуудлыг ТУЗ болон компанийн удирдлага анхааралдаа авч өгөөч. Хүний эрүүл мэндийн хамгийн эхний асуудал нь цэвэр ус шүү дээ.

Орон нутгийн өмчийн төлөөлөгч Ц.Бэхбаяр: Могойн гол тосгоны гидрогеологийн нөхцөл нь хүнд юм байна лээ. Бид 15 сая төгрөг баталж 45 м-ийн гүнд өрөмдөөд ч ус гараагүй мөнх цэвдэгтэй учир нэлээд хэцүү гэж байсан.

Өнөөдрийн хуралтай холбоотойгоор өчигдрөөс эхлэн “Могойн гол” ХК-ийн 51%-ийн хувьцааг аймгийн ИТХ-ын дарга, Аймгийн засаг дарга нар хуйвалдан зарах гэж байна гэсэн хардлагатай мэдээллүүд явж эхлээд байна. Хөвсгөл аймгийн орон нутгийн өмч болох 423107 ширхэг хувьцааг зарах асуудал огт байхгүй гэдгийн хэлмээр байна. Үүнтэй холбоотойгоор телевизүүдийг урьж энэ удаагийн хурлаа нээлттэйгээр ил тод хийж байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Тогтоолын төслийг танилцуулав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

**ХЭЛЭЛЦСЭН нь: 3 Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал**

**СОНССОН нь:** ТУЗ-ийн дарга Б.Базардамбуу танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигч Ж.Батболд: Санал байхгүй.

Хувьцаа эзэмшигч Л.Батдэлгэр: Урьдчилан танилцсан учир санал байхгүй.

Хувьцаа эзэмшигч Ц.Бэхбаяр: Санал байхгүй.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Тогтоолын төслийг танилцуулав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

**ХЭЛЭЛЦСЭН нь: 4 Компанийн ногдол ашиг хувиарлах талаар ТУЗ-ийн дүгнэлт:**

**СОНССОН нь:** ТУЗ-ийн дарга Б.Базардамбуу танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигч Ж.Батболд: Асуулт байхгүй. Саналаа дараа нь хэлнэ ээ.

Хувьцаа эзэмшигч Л.Батдэлгэр: ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Манай компанид 900 гаран хувьцаа эзэмшигчид байгаа. Хувьцаа нь тодорхой хэмжээнд төвлөрсөн. Цаана нь 800 гаран жижиг хувьцаа эзэмшигч байгаа. Компани өргүйгээр ажиллах боломжийг бүрдүүлж ажиллах хэрэгтэй. Манай компанийн хувьд 1 тэрбум гаран төгрөгний өртэй ажиллаж байгааг ТУЗ-д ажиллаж байгаагийнхаа хэрээр мэдэж байна. Бид 20, 30 сая төгрөгний ашигтай байсан үедээ ч ногдол ашиг хуваарилаж ирсэн. Нийт бүх хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг бодолцож одоогийн хурлаараа хувьцааны ногдол ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэх санал гаргаж байна.

Хувьцаа эзэмшигч Т.Бат-очир: Батдэлгэр даргатай санал нэг байна. Ногдол ашгаа тараах нь зүйтэй. Энэ асуудлыг авч хэлэлцэх хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч Ч.Гүнсэнноров: Бид хувьцаагаа зарах эсэх нь хөрөнгийн зах зээл дээр нээлттэй байгаа. Энэ уурхайтайгаа олон жил хамтран ажилламаар байгаа хэдий ч төр өөрөө оролцсоор байгаад ийм байдалд хүргэж байна. Хувьцаа эзэмшигчид экспортын нүүрсийг тээвэрлэх асуудал дээр оролцоогүй. Энэ бол та бүхний улс төрийн л ажил шүү дээ. Тэрнээс үүдэж энэ компани ашиггүй ажиллаж байна. Ямар зорилгоор энэ компанийг ашиггүй ажиллуулаад байгаа юм. Улс төржөөд байгаа юм уу. Маш олон хувьцаа эзэмшигчид жилийн турш ногдол ашгаа хүлээгээд сууж байгаа. Ногдол ашгаа тараах нь зүйтэй. Төр үнэхээр оролцдог юм бол төр өөрөө хариуцлагаа хүлээх ёстой.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ц.Мөнгөншагай: Миний хувьд урт хугацааны төлөвлөлтийг хийж байхдаа ярьж байсан. Тиймдээ ч компани жил жилийн бизнес төлөвлөгөөнд баригдаж ажиллаж байна. Үүнээс үүдэн ногдол ашиг хуваарилах асуудал нь гэнэтийн шийдвэр болчихоод байна. Урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулчихсан байвал хувьцаа эзэмшигчдэд шийдвэр гаргахад хялбар болно. Гэнэт их хэмжээний ногдол ашиг хувиарлах, эсвэл ногдол ашиг хувиарлахгүй байх асуудал нь жигд үйл ажиллагааг алдагдуулж байна. Өнөөдрийн байдлаар компани нэлээдгүй хэмжээний өр төлбөртэй байгаа энэ үед заавал ногдол ашиг авна гэж компанид шахалт үзүүлэх нь дараа дараагийн жилүүдийн үйл ажиллагаанд шууд хохиролтой, дампууралд хүргэх аюултай юм. Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа зарах эсэх нь тухайн хүний сонголтын асуудал. Компанийн зүгээс урт хугацааны буюу хэдэн жилийн дараагаас хэр хэмжээний ногдол ашиг хуваарилах талаар боловсруулсан байвал хувьцаа эзэмшигчдэд шийдвэр гаргахад нь нөлөөлөх юм.

Орон нутгийн өмчийн төлөөлөгч Ц.Бэхбаяр: 2019 онд ногдол ашиг хуваарилахгүй гэсэн ТУЗ-ийн шийдвэр гарсан нь тодорхой үндэслэлтэй. Өнгөрсөн жил үйл ажиллагаа ашигт байдал сайтай байсан хэдий ч жилийн дундуур бидний тооцоолоогүй эрсдэл үүсэж үйл ажиллагаа доголдсон. Өнгөрсөн жилийн ногдол ашиг болох 1 тэрбум төгрөгний орон нутгийн ногдол ашиг болох 510 сая төгрөгнөөс 490 сая төгрөг нь олгогдоогүй байгаа. Үүнээс үүдэн орон нутгийн төлөвлөсөн нилээдгүй ажил хойшилсон товлосон хугацаандаа хийгдээгүй. 49%-даа 490 сая төгрөгийг цаг хугацаанд нь олгосон. Төр өнөөдөр ард иргэд, хамтран ажиллаж буй хувьцаа эзэмшигчдийн өмнө харилцан буулт хийгээд ажиллаж байна. Энэ ч ногдол ашиг хуваарилахгүй байх энэ шийдвэрт нөлөөлсөн.

Хувьцаа эзэмшигч Ч.Гүнсэнноров: 1990-ээд онд нүүрс борлогдохгүй, нүүрс аваач гэж гуйж явсан үе бидэнд бий. Одоо гэтэл нүүрсийг нь авъя гэж олон газраас хүсэлт ирж байхад борлуулахгүй байна гэдэг нь албаар энэ компанийг дампууруулах гэсэн бодлого явагдаж байна. Эсвэл ашиг сонирхол байна. хуучин бид хамгийн хэцүү үедээ ч 3 төгрөг, 5 төгрөг, 9, 10 төгрөгний ногдол ашгийг хуваарилаж байсан.

Хувьцаа эзэмшигч Ж.Батболд: Ногдол ашгийг бид ТУЗ-ийн хурал дээр шийдвэрлэсэн. Компанийн өр төлбөртэй байгаа асуудал нь ногдол ашиг хуваарилах эс хувиарлах нь хамааралгүй. Тухайн санхүүгийн жилд ашигтай ажилласан бол ногдол ашиг хуваарилана гэдэг. Харин өр төлбөрийн асуудал нь компанийн удирдлагуудын мөнгөн урсгалыг хэрхэн жолоодож авч явж байгаатай холбоотой. Гэвч одоо эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж байгаа тул энэ тогтоолоо эргэн нэг харж ногдол ашиг хуваарилах асуудлыг дахин хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна. 2019 онд бид нэгж хувьцаанд 1205.36 мөнгө хуваарилаж байсан. Хувьцаа эзэмшигч Ч.Гүнсэнноров нэлээдгүй үндэслэлтэй зүйл ярьж байна. Энэ саналыг би бас хүндэтгэж үзээд нэгж хувьцаанд 200-400 төгрөгний ногдол ашиг хуваарилавал яасан юм бэ гэсэн бодитой санал оруулж байна. Мөн ногдол ашиг хуваариладаг уламжлал тасрах гээд байна. Энэ асуудал дээр компанийн удирдлагын саналыг сонсьё. Манай компанийн хувьцааг Монгол улсын 902 аж ахуй иргэд, гадаадын 26 иргэн аж ахуй нэгжүүд эзэмшиж байна.

Компанийн гүйцэтгэх захирал Б.Хашбат: 2019 онд компани өөрийн боломжийн бүх хүчин чадлыг дайчлан ажилласан. Санхүүгийн бүх боломжоо ашигласан. Энэ жилийн хувьд бизнес төлөвлөгөөнд хүрч ажиллаагүй. Хөрс хуулалтын ажил төлөвлөгөөт зорилтдоо хүрч ажиллаж чадаагүй. Манай компанийн эрдэнэтрүү явж байгаа нүүрсний тээвэрлэлт дээр хяналт тавьдаг хэдий ч бусад 60-100 тоннын даацтай машинууд төрөл бүрийн бараа бүтээгдэхүүн, бусад үйлчилгээний тээвэрлэлтийг хянадаггүй, Хөвсгөл дулааны станцын зүүн зүгийн сумдын уурын зуухнуудад очиж буй нүүрс тээвэрлэлт хяналтгүй явж байгаа. Үүн дээр цэвэр улс төржилт орсон. Өнгөрсөн жил ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэд 490 сая төгрөг тараасан. Орон нутагт өгөх 510 сая төгрөг хуваарилагдсан боловч 20 сая төгрөгийг өгч үлдсэн 490 сая төгрөгийг өгөөгүй байгаа нь үнэн. Мөн 2020 оны зорилт хөрс хуулалт 1850 мян.мкуб, нүүрс борлуулалт 160 мян.тонн, нүүрс олборлолт 200 мян.тонн гэж байгаа. Ямар нэгэн байгууллага өөрийн орлого ашгаас ажил төрлөө нэмэгдүүлэх, цар хүрээгээ тэлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг. Энэ бүгд компанийн орлого мөнгөн хөрөнгөтэй шууд холбоотой. Компанийн үйл ажиллагаа доголдсон. Өнөөдрийн байдлаар дансандаа 30 хүрэхгүй сая төгрөгтэй 5-р сарын цалингаа тавьж чадахгүй байдалд хүрчихсэн ажиллаж байна. Эцсийн буруу бол төрд байна. Хувьцаа эзэмшигчид болон компанийн удирдлагууд энэ компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилготой ажилладаг. Борлуулалтын тал дээр асуудал байгаа юм. Хэрэв компанийг үнэхээр ашигтай ажиллуулъя гэж бодож байгаа бол хамгийн өндөр үнэтэй авъя гэж байгаад нь өгч болно шүү дээ. Хамгийн өндөр ашигтай ажиллах тэр боломжийг тал бүрээс нь хангаж ажиллах хэрэгтэй. Миний хувьд нүүрсний үнийг ялангуяа экспортын нүүрсний үнийг ТУЗ-өөс тогтоодог асуудлыг буруу гэж үздэг. Бид 2020 оны төлөвлөгөө зорилтыг нэлээдгүй өндөр тавьсан. Энэ зорилтод хүрч ажиллахын тулд хөрөнгө оруулалтыг ч мөн сайн хийх

хэрэгтэй. тиймээс энэ жилийн хувьд нэг удаадаа ногдол ашиг тараахгүй байв  
яасан юм бэ гэсэн саналыг компанийн зүгээс ТУЗ-д тавьсан юм. Үүн дээр ТУЗ-и  
тогтоол гарч ажилласан.

Орон нутгийн өмчийн төлөөлөгч Ц.Бэхбаяр: "Могойн гол" ХК 50 жилийн  
түүхтэй компани төр өөрт байсан 49%-ийн хувьцааг 1991 онд хөрөнгийн зах зээл  
дээр арилжаалсан. Төр өөрийн өмчийг хамгаалж, иргэн өөрийн өмчийг хамгаалах  
энэ хуралд суудаг. Хувьцаа эзэмшигч болон төр 2 зөвшилцөж байж бүх шатны бүх  
хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гардаг.  
Бидний үйл ажиллагаа доголдоход ихээхэн нөлөө үзүүлж байгаа компани бид  
Хөвсгөл дулааны станц юм. Завхан, Хөвсгөл 2 аймаг жилдээ 60 гаран мянган тонн  
нүүрс хэрэглэж байгаа үүний 10 гаруй мянган тонн нүүрсийг дулааны станц авдаг.  
Дулааны станцын өр төлбөр өнөөдрийн байдлаар 300 гаран сая төгрөг, Оргил үед  
600 сая болж байсан. Гүнсэnnоров хувьцаа эзэмшигчийн хэлж байгаа нь нэг талд  
зөв л дөө. Гэвч Хөвсгөл аймгийн мөрөн сумын 40.0 мянган айл өрх, алба  
байгууллага байдаг. Эдгээр хүмүүсийг хөлдөөчихгүйн тулд бид бүхэн орон нутгийн  
өмчит аж ахуй нэгжрүүгээ ханддаг нь үнэн. Дулааны станц гэдэг компани нь төрийн  
өмчит компани. Бид бүхэн Батболд ТУЗ-ийн гишүүнээр ахлуулсан, миний бид  
оролцсон ажлын хэсэг байгуулж шинээр томилогдсон захиралтай нь уулзалт хийж  
графикийн дагуу өр төлбөрөө барагдуулах асуудлыг ярилцсан. Хувьцаа эзэмшигч  
компанийн цаашдын үйл ажиллагааг харж ТУЗ-ийн шийдвэрийг дэмжж  
ажиллаасай гэж хүсэж байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Тогтоолын төслийг танилцуулав. Хурлын дэгийн да  
хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

**ХЭЛЭЛЦСЭН нь 5:** Эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс гаргасан санал  
дагуу "компанийг өөрчлөн байгуулах тухай" төслийг хэлэлцэн шийдвэрлэх

**СОНССОН нь:** Хувьцаа эзэмшигч Ж.Батболд танилцуулав. /танилцуул  
хавсаргав/

Энэ асуудал нь өмнөх асуудлуудтай холбоотой. Өнгөрсөн 10 гаруй жилийн  
хугацаанд аймгийн зүгээс компанийн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдийн  
зөвшөөрөлгүйгээр бусад компаниуд руу шилжүүлэх, ашиг орлогод саад учруул  
тохиолдлууд удаа дараа гарч байсан. Энэ зөвхөн өнөөдөр болж байгаа үйл явд  
биш юм. Энэ бүх үйл ажиллагааны хүрээнд компанийн үйл ажиллагаа доголдо  
байна. Компанийн тухай хуулийн 18, 22, 23 дугаар зүйлд заасны дагуу энэ компан  
өөрчлөн байгуулах цаг болсон байна гэж үзээд энэ саналыг гаргаж байна. Гадаад  
маш олон хувьцаа эзэмшигч байдгаас хамгийн их хувьцаа эзэмшиж бай  
Транснефвь компанийн захирал К.Д.Романовский байдаг. Энэ хүн өнгөрсөн  
хугацаанд өөрийн саналаа хэлж байсан. Энэ компанийн үйл ажиллагааг цааш  
төрийн оролцоотой явуулахад нэлээдгүй хүндрэлтэй байна тийм учраас цааш  
компанийг өөрчлөн байгуулах, тусгаарлах, хуваах зарчмаар шийдвэрлэх хэрэгтэй  
Төрийн оролцоо маш их байгаа тул Төр 51%-ийн өмчөө тусад нь авч ХХК, 49% -  
нь ХК хэлбэрээр өөрчлөн байгуулах саналтай байгаа юм.

Энэ асуудал дээр маш их судалгаа, ажил хийгдэх шаардлагатай. Өнөөг  
компанийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, үүнийг бид хийсэн байгаа. Үүн

тулд дараах тооцоолол үндэслэлийг гаргасан. Компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд санхүүгийн байдал ашиг орлогын төвшинг харуулж дүгнэлтээ бичсэн байгаа. Өнгөрсөн хугацаанд бид зөвшилцөөд явахыг хичээсэн. Нүүрс олборлолтыг 500 мянган тонн-д хүргэж 15 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийж, жилийн 6 тэрбум төгрөгний ашигтай ажиллах боломжтой гэж 2019 онд ярьж байсан. Гэтэл аймгийн ИТХ-ын хуралдаанаар энэ асуудал хөндөгдөхөөргүй болсон. Тийм учраас цаашид компанийг хуваан тусгаарлан аймаг нь эрчим хүчний зориулалттайгаар, 49% нь арилжааны чиглэлээр ажиллан олон улсын зах зээлд гарч ажиллах хэрэгтэй гэсэн үндэслэлээр төсөл хөтөлбөрүүдийг хийж ажиллаж байна.

Үүний үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, компанийн тухай хуульд зааснаар маш олон газруудтай уулзалт хийсэн. Бид нэгэнт асуудлаа гаргасан тул та бүхэн саналаа өгнө үү. Энэ гарын авлага дээр дэлгэрэнгүй байгаа.

Хувьцаа эзэмшигч Л.Батдэлгэр: Хувь нийлүүлэгчдийн зүгээс оруулж буй хуваах үйл ажиллагааг ерөнхийд нь дэмжиж байгаа. Дэмжих үндэслэлийг сая маш тодорхой ярилаа. Та бүхний ногдол ашгаа авна гэдэг нь зөв. Гэхдээ эцэст нь гарах шийдвэр нь тодорхой байна. Байгууллагын үйл ажиллагааг бид мэдэж байгаа. 800 гаран хувь нийлүүлэгч цаана нь байгаа. Энд тодорхой хэмжээнд төвлөрсөн 30 гаран хувь эзэмшигчид оролцож байна. Яагаад ийм санал оруулаад байгааг та бүхэн тунгааж ойлгох байх.

Хувьцаа эзэмшигч Т.Бат-Очир: Энэ асуудал дээр олон хувьцаа эзэмшигчид санал гаргаж байгаа тул би бас үүнийг дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч Ч.Гүнсэнноров: Компани хуваах, хуваагдах гэж байгааг саяхнаас мэдээд маш их зүйл бодож суулаа. Хэрэв бие биетэйгээ ойлголцоод ажиллавал бидэнд хэн хэнд нь хэрэгтэй байна. Энэ санал тавьсан хүмүүсийн саналыг дэмжиж байна. Үнэхээр төр мэдээд байгаа юм бол дулааны станцын өгөх ёстой 300 гаран сая төгрөгийг та бүхэн өгөөч дээ. Одоо мөнгөгүй ажил сайн хийхгүй байгаа бол энэ жилдээ ажил хийхгүй юм байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ц.Мөнгөншагай: Энэ санал учир шалтгаан нь бол тодорхой байна. Төрийн оролцоо их байна гэдэг ерөнхий шалтгаантай. Энэ шалтгааныг нь дэмжиж байгаа. Гэхдээ цаашид гарах үр дагавар нь юу вэ гэдгийг бодох хэрэгтэй. Хэрэв хуваагдлаа гэхэд уурхайн тэлэлт, бусад технологийн горимд нь ямар нөлөө үзүүлэх, хажууд нь том уурхай байгуулагдах гээд байна. Тэр үед өрсөлдөх чадвар нь ямар байх вэ? хуваагдах тусам бизнесийн үйл ажиллагаа явуулах боломж бололцоо нь муудна. "Могойн гол" ХК дээр зохистой менежмент хийж, засаглалыг сайжруулах асуудал дутагдаад байгаа юм байна гэж миний зүгээс харж байна. Цаашид ТУЗ –нь ТУЗ-ийн эрхийн хүрээнд үйл ажиллагааг явуулж компанийн дотоод үйл ажиллагаа руу оролцохгүй явах юм бол илүү үр дүнтэй байх болов уу гэж бодож байна. Миний хувьд хуваагдахгүй байх санал гаргаж байна.

Орон нутгийн өмчийн төлөөлөгч Ц.Бэхбаяр: Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны 33-р тогтоолоор энэ хурлын удирдамжийг баталж өгсөн. Бид зөвшилцлийн үндсэн дээр шийдвэр гаргадаг. Компанийн тухай хууль болон "Могойн гол" ХК-ийн дүрэм дээр ч байдаг 66.6%-ийн буюу дийлэнх олонхийн саналаар шийдвэр батлагддаг. 9 гишүүний 6 нь дэмжиж байж батлагдана гэсэн үг.

Түрүүнээс хойш төр дангаараа шийдээд байгаа юм шиг яригдаад байна. Маш том өрсөлдөгчийн өмнө баг болж ажиллах ёстой. Аспайр майнинг гэдэг компани ашиглалтын лицензээ авчихсан, Австралийн хөрөнгийн зах зээл дээр хувьцаагаа гаргачихсан, асар их нөөцтэй гэтэл бид 10,2 сая тонн нүүрсний нөөцтэй шүү дээ. Энэ компани бол 280 сая нүүрсний нөөцтэй стандартаар нөөцөө тогтоолгочихсон маш том, мөнгөтэй компанийн өөдөөс 50 жилийн түүхтэй компаниа 2 хуваачихсан байх нь нэгдүгээрт зохимжгүй, хоёрдугаарт хамгийн амархан ялагдал хүлээнэ.

Бид аймагтаа, аймгийн ИТХ-д, аймгийн 41 төлөөлөгчиддөө ойлгуулах ажлыг зохион байгуулая. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид энэ асуудлыг ойлгоод татгалзах санал өг, нэг тийшээ харж ажиллая гэдгийг ярьж ойлгуул гэсэн удирдамж чиглэлийг надад өгсөн. Тийм учраас та бүхэн ойлгоорой. Алдаатай, оноотой асуудлуудаа аймгийн удирдлагууддаа ойлгуулая. Би хувь хүнийхээ хувьд хардаж байна. Аспайр майнинг гэдэг компани өрсөлдөгчийнхөө хувьд тодорхой хэмжээний ажлыг зохион байгуулж байна. Төрийн бус байгууллагуудыг ажиллууж мөнгийг нь өгч байна. Тэдгээр хүмүүс нь асуудлыг дэвэргэж байна. Судалгаа нотолгоонд суурьлаагүй шийдвэрийг оруулж байна. Тийм учраас энд тодорхой шийдвэрүүд гарсан байх магадлалтай. Тиймээс бид бүхэн судалгаа тооцоогоо оруулая. Энэ асуудлыг бид маш нухацтай ярилцах ёстой. Бидний хажууд маш том уурхай байгуулагдаад явж байна. Энэ асуудал хэрэв хуваагдахаар шийдэгдвэл бид маш том эрсдэлд орно. Алдаа оноотой асуудал байгаа бол бид бүхэн Аймгийн ИТХ, Засаг дарга, Тэргүүлэгчдэд танилцуулж ойлгуулая. Аймгийн ИТХ, тэргүүлэгчид энэ асуудлыг ойлгоод хувь талтайгаа нэгдэж нэг тийшээ харж ажиллая. Үүнийг хувьцаа эзэмшигчиддээ ойлгуулаарай гэсэн үүрэг даалгавар өгсөн. Зам тээвэртэй холбоотой асуудлаа шийдвэрлүүлье гэсэн зорилготой ажиллая. Аспайр майнингийн гаргаж байгаа зарим шийдвэрийг дагаж байгаа асуудлыг зогсоох тал дээр ажиллая. Эрдэнэт рүү явуулж байгаа буюу экспортын нүүрсний замын асуудлыг шийдвэрлүүлэх тал дээр онцгой анхаарч нэг чиглэлд харж ажиллая. Та бүхэн энэ асуудал дээр нухацтай хандаасай гэж хүсэж байна.

Хувьцаа эзэмшигч Ч.Гүнсэнноров: Үнэхээр орон нутгийн компани олон улсын Аспайр майнинг компанитай зэрэгцээд ажиллаасай гэж хүсэж, бодож байгаа бол та нар өнөөдөр энэ компанийг ийм байдалд оруулах ёсгүй. Эдийн засгийг улам чадавхижүүлж экспортын нүүрсийг явуулах ёстой. Экспортын нүүрсний тээвэрлэлтийг хэн зогсоож компанийн үйл ажиллагааг доголдуулсан юм. Тэр бол төрийн 51%, Өнөөдөр хувьцаа эзэмшигчдийн хэн ч энд оролцоогүй. Энэ телевизын бичлэг ч тодорхой хугацаанд хадгалагдах хэрэгтэй. Сумдын уурын зуухнуудыг улсын төсвөөр засварлаад хувьчилахад бэлэн болгочихсон. Нэмээд уурхайн 51%-ийг хувьчилж авах юм гэнэ лээ гэсэн цахим мэдээ байхыг хараад би үнэхээр харамсаж байсан. Бидний бодож явсан хувьцаа эзэмшигчдийн хүсэл зорилгыг ингэж доош нь оруулж байгаад би харамсаж байсан. Цаг хугацаа бүхнийг харуулна шүү. Өнөөдөр хувьцаа эзэмшигчид нүүр нүүрээ харж ярих ёстой.

Хувьцаа эзэмшигч Л.Батдэлгэр: Хамгийн гол асуудал нь төр гэдгээр давамгайлаад байж болохгүй. Заавал сална гээд 2 тийшээ харж суучихаад байгаа зүйл ч яг биш шүү дээ. Мөн би ТУЗ-ийн даргын хувьд шийдвэр гаргаж байгаа юм гээд байж болохгүй. ТУЗ-ийн дарга гэдэг чинь 9 гишүүн дотроо хэнээр даргаа тавих вэ гээд сонгогддог. Аливаа асуудал дээр төр гэдгээр давамгайлаад байхаар чинь

хаана хаанаа асуудал үүсээд байна. Би энэ компанийн удирдлагаар ажиллаж байсан. Өмнө нь төр ингэтлээ оролцож байгаагүй. Компанийн тухай гарсан цахим мэдээллүүд дээр тулгуурлан ярьж болохгүй шүү. Бид бодит зүйл дээр тулгуурлан ярих хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч Ж.Батболд: Манай компанийн үйл ажиллагаа, өргөжин дэвших нь аль нэгэн 3 дагч этгээдийн оролцоогүй. Бид энэ компаниа аль болох өсөн дээшилсэн, аймаг орон нутагдаа үр өгөөжөө өгсөн, мөн хувийн хэвшлийн менежмент хэрхэн явдагийг харуулсан компани болгохоор зорьж байгаа юм. Бид бүхний дэвшүүлсэн энэ асуудал дэмжигдсэн ч бай, дэмжигдээгүй ч бай бид ахин дахин тавих болно. Бид өмнө жил нэг санал тавьж байсан. Компанид нэмэлт хувьцаа гарган төрийн хувьцааг бага хэмжээгээр ч болов бууруулах санал тавьсан хэдий ч шийдэгдээгүй. Энэ асуудлыг олон нийт зөв ойлгох хэрэгтэй. Компанийг хуваах, өөрчлөн байгуулах асуудал нь компанийн тухай хуульд заасан байдаг асуудал юм шүү. Хэрэв энэ асуудал дэмжигдвэл аймаг орон нутагтаа үр өгөөжөө өгсөн компани болно гэдэгт хувьцаа эзэмшигчид бид маш их итгэлтэй байгаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Базардамбуу: Эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс гаргасан саналын дагуу хувьцаа эзэмшигчид асуулт саналаа хэллээ. Компанийн гүйцэтгэх захирал Б.Хашбатын саналыг сонсьё.

Компанийн гүйцэтгэх захирал Б.Хашбат: Хувьцаа эзэмшигчдийн яриад байгаа зүйл нь үнэн л дээ. Асуудал үүсвэл ногдол ашгаас авч байгаа мөнгөөрөө хийх хэрэгтэй гэж бодож байна. Тэгэхгүйгээр асуудал үүсвэл "Могойн гол" гээд байгаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх тэгш байдлыг алдагдуулж байгаа. Миний хувьд энэ асуудлыг дэмжихгүй байна. Компани хөрөнгө мөнгө, техник тоног төхөөрөмжийн хувьд боломжтой байсан бол ямар байх вэ гэхээс биш өнөөдрийн тухайд 2 хуваагдаад сайн ажиллана гэдэг өрөөсгөл байх гэж бодож байна. Төр нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг бодолцож, хувьцаа эзэмшигчдээ хүндэтгээд хоорондоо ойлголцоод ажиллах нь хамгийн зүйтэй байна. Компанийг хуваах, өөрчлөн байгуулах нь одоогийн байдлаар зохимжгүй юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ч.Уртнасан: Бид хувьцаагаа нийлүүлсэн учир компанийн үр ашгаас хүртээд явна гэдэг нь ойлгомжтой. Төрийн 51%-ийн хувьцаа орон нутгийн өмчинд байна. Монгол улсын хэмжээнд энэ компанийг амжилттай ажиллаад явахад ямар менежмент хийх шаардлагатай байгааг нэн тэргүүнд тодорхойлох хэрэгтэй. Манай уурхайн нөөц олон удаа хайгуул хийгдэж нөөц нь янз бүрээр гарч байсан байна. Ойролцоогоор 7.6-9.0 сая тонн нүүрсний нөөцтэй юм байна. Миний хувьд уурхайн 50 жилийн түүхэн дээр нь тараачихмааргүй л байна. 49%-ийн тал нь арилжааны хэлбэрээр, 51% нь орон нутгийн хэрэгцээнд гээд бодоход цаашид хэрхэх вэ гэдэг асуудал тулгарна. Энэ байдлыг тал талаас нь бодолцох ёстой. Төрийн байгууллага давамгайлж болохгүй. Гэхдээ төр бол иргэд олон нийтийн дуу хоолойг сонсож ажиллах үүрэгтэй байдаг. Яагаад экспортын зориулалттай нүүрс тээврийг хориглосон бэ гэхээр өмнөх оны 2,3-р сард баахан зам эвдэрлээ, Хилэнтийн гүүр нурлаа гээд л олон нийт хэвлэл мэдээллээр шуурсан. Мөн улсын мэргэжлийн хяналтын газраас албан шаардлага ирсэн байсан. Үүнийг үндэслэн аймгийн ИТХ-ын хуралдаанаар уг шийдвэр гарсан. Мэргэжлийн хяналтаас ирсэн бичигтэй танилцахад нэг уурхайд ахадмаар, авто замын төлөвлөгөө боловсруулж, тооцоолол хий гэсэн утга бүхий бичиг байсан.

Мэдээж хэрэг хариуцлагатай уул уурхай гэдэг нь хариуцлагатай л байх ёстой. Үүний тулд бид маш их бодолтой байх хэрэгтэй. Өрсөлдөгч том компанийн асуудал орж ирж байна. Ийм эгзэгтэй цаг үед аль болох ойлголцоод ажиллах хэрэгтэй гэж үзэж байна. Уул уурхайгүй хөвсгөл гээд төрийн бус байгууллага гарч ирээд жаал бужигнуулсан. Хөвсгөл аймгийг уул уурхайгүй хөгжүүлчих юм шиг зүйл ярьж байгаа. Гэхдээ ингэж болохгүй. Бид ой модоо тайрч түллээ гэхэд хэр их хэмжээний мод түлэх билээ бас л бодох асуудал шүү дээ. Цаашид бид нэгдмэл байдлаар ажиллах, энэ цаг үед нэгдэж нийлж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Ногдол ашиг хуваарилах асуудал яригдаж байна. Компанийн үйл ажиллагаа доголдсон замын тээвэрлэлт хаагдсан нь компани болон ТУЗ-өөс шалтгаалаагүй асуудал шүү дээ.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Тогтоолын төслийг танилцуулав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудасаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

**ХЭЛЭЛЦСЭН нь 6: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох**

**СОНССОН нь:** ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Золбоо танилцуулав. /танилцуулгыг хавсаргав/

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Тогтоолын төслийг танилцуулав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудасаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

Тооллогын комисс саналын хуудасны саналыг нэгтгэж хуралд оролцогчидод мэдээллэв.

Хурал даргалагч Б.Базардамбуу шинээр байгуулагдсан ТУЗ-д амжилт хүсч хурал хаав.

Хурал 16 цаг 20 минутад тарав.

**ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:**

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Б.ЗОЛБОО

**ТАНИЛЦСАН:**

ДАРГА 

Б.БАЗАРДАМБУУ

